

2018 оны I улирал

НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2018
оны I улирлын санхүүгийн тайлангийн
нэгтгэлийн танилцуулга

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага
тойруу 3, Засгийн газрын IV байр. Утас: 51-261668

Агуулга

| | |
|---|----|
| | 0 |
| Хүснэгтийн жагсаалт..... | 6 |
| Зургийн жагсаалт..... | 6 |
| 1. Салбарын өнөөгийн байдал..... | 1 |
| 1.1 Ерөнхий төлөв байдал..... | 1 |
| 1.2 Статистик үзүүлэлтүүд..... | 2 |
| 2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа..... | 6 |
| 2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт..... | 6 |
| 2.2 Зээл..... | 8 |
| 2.2.1 Зээлийн зориулалт..... | 8 |
| 2.2.2 Зээлийн багцын чанар..... | 9 |
| 2.2.3 Зээлдэгчид..... | 9 |
| 2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү..... | 10 |
| 3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт..... | 11 |
| 3.1 Өр төлбөр..... | 11 |
| 3.2 Эздийн өмч..... | 13 |
| 4. Орлого, үр дүнгийн тайлан..... | 14 |
| 4.1 Орлого..... | 14 |
| 4.2 Зарлага..... | 15 |
| 4.3 Ашигт ажиллагаа..... | 16 |
| 5. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт..... | 16 |
| 5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт..... | 17 |
| 5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт..... | 17 |
| 5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт..... | 18 |
| 6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД..... | 20 |
| 6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд..... | 20 |
| 6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд..... | 21 |
| 6.3 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд..... | 22 |
| ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ..... | 24 |
| ДҮГНЭЛТ..... | 24 |

Хүснэгтийн жагсаалт

| | |
|---|----|
| Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл..... | 1 |
| Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо..... | 2 |
| Хүснэгт 3 Харилцагчид 2018-I | 2 |
| Хүснэгт 4 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/ | 3 |
| Хүснэгт 5 ББСБ-уудын тархалт /хот/ | 4 |
| Хүснэгт 6 ББСБ-уудын тархалт /орон нутаг, бүсээр/ | 4 |
| Хүснэгт 7 Активын бүтэц /сая төгрөгөөр/..... | 6 |
| Хүснэгт 8 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/ | 6 |
| Хүснэгт 9 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/ | 8 |
| Хүснэгт 10 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/ | 9 |
| Хүснэгт 11 Ерөнхий статистик /харилцагчид/ | 9 |
| Хүснэгт 12 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/ | 11 |
| Хүснэгт 13 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/ | 12 |
| Хүснэгт 14 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/..... | 12 |
| Хүснэгт 15 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/ | 14 |
| Хүснэгт 16 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая,төг/..... | 15 |
| Хүснэгт 17 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/..... | 16 |
| Хүснэгт 18 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШҮ..... | 17 |
| Хүснэгт 19 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШҮ..... | 17 |
| Хүснэгт 20 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ..... | 18 |
| Хүснэгт 21 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл..... | 20 |
| Хүснэгт 22 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц | 21 |
| Хүснэгт 23 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц | 21 |
| Хүснэгт 24 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл | 21 |
| Хүснэгт 25 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив..... | 22 |
| Хүснэгт 26 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив..... | 22 |
| Хүснэгт 27 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив..... | 23 |
| Хүснэгт 28 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн мэдээ /2018-I улирал/..... | 23 |

Зургийн жагсаалт

| | |
|---|---|
| Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо..... | 1 |
| Зураг 2 Хорооны тогтоол 2018-I /ББСБ/ | 1 |
| Зураг 3 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо | 2 |
| Зураг 4 Санхүүгийн програм ашиглалт..... | 3 |
| Зураг 5 Програмын төрлүүд /програмтай ББСБ-уудын хувьд/..... | 4 |
| Зураг 6 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт..... | 4 |
| Зураг 7 Мөнгөн хөрөнгө /сүүлийн 5 жилээр/..... | 7 |
| Зураг 8 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая.төг/ | 7 |
| Зураг 9 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /2018 оны I улирал/..... | 7 |
| Зураг 10 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/ | 8 |
| Зураг 11 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/..... | 8 |
| Зураг 12 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/..... | 8 |
| Зураг 13 Зээлийн чанар /хувиар/ | 9 |
| Зураг 14 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа..... | 9 |


| | |
|---|----|
| Зураг 15 Зээлдэгчдийн боловсрол | 10 |
| Зураг 16 Зээлийн жигнэсэн дундаж хүү..... | 10 |
| Зураг 17 Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 12 |
| Зураг 18 Бусад эх үүсвэрийн бүтэц | 12 |
| Зураг 19 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/ | 13 |
| Зураг 20 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг..... | 13 |
| Зураг 21 Бусад пассив /сая төгрөгөөр/..... | 13 |
| Зураг 22 Пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/ | 14 |
| Зураг 23 Ашигт ажиллагааны үзүүлэлт..... | 14 |
| Зураг 24 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/ | 15 |
| Зураг 25 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/..... | 15 |
| Зураг 26 Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 15 |
| Зураг 27 Ашгийн өсөлт /хувиар/ | 16 |
| Зураг 28 Зохистой харьцаа | 16 |
| Зураг 29 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт | 20 |
| Зураг 30 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц | 21 |
| Зураг 31 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн /2017-2018 оны 1-3 сар/..... | 23 |

1. Салбарын өнөөгийн байдал

1.1 Ерөнхий төлөв байдал

2018 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 537 ББСБ байна. Энэ нь 2017 оны I улирлаас 11 ББСБ буюу 1.5 хувь, оны эцсээс 6 ББСБ буюу 0.6 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 1 Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



2018 оны I улирлын байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ байгаа бол хөдөө орон нутагт 76 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 оны I улиралд Хорооны хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлыг авч үзвэл:

Зураг 2 Хорооны тогтоол 2018-I /ББСБ/



5 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 7 ББСБ-д 10 тусгай зөвшөөрөл нэмж олгох, 2 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох, 1 ББСБ-ын 2 төрлийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 1 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь түдгэлзүүлэх, 1 ББСБ-ын гадаад валют арилжааны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн түдгэлзүүлэх, 2 ББСБ-ыг нэгтгэхийг зөвшөөрөх зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

| | 2014-I | 2015-I | 2016-I | 2017-I | 2018-I |
|------------------|------------|------------|------------|------------|------------|
| Шинээр олгосон | 28 | 18 | 15 | 13 | 5 |
| Хүчингүй | 2 | 1 | 2 | 2 | 2 |
| Түдгэлзүүлсэн | 1 | 2 | 0 | 17 | 1 |
| Сэргээсэн | 0 | 0 | 0 | 0 | 1 |
| Нийт ББСБ | 289 | 395 | 463 | 529 | 537 |

2018 оны I улиралд банк бус санхүүгийн салбартай холбоотой Хорооны даргын 188 тушаал гарчээ. Үүнээс 177 тушаалаар 171 ББСБ /3 ББСБ 2 удаа өөрчлөлт оруулсан/ 47.6 тэрбум төгрөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж, 4 ББСБ оноосон нэрээ өөрчилсөн бол 6 ББСБ 15 салбар нээж, 1 ББСБ-ын 2 салбар хаах асуудлыг шийдвэрлэсэн байна.

Үйл ажиллагааны төрөл

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 2018 оны I улирлын байдлаар 537 ББСБ 9 төрлийн 760 тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын 90.5% буюу 486 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 66.9% буюу 359 ББСБ дагнан эрхэлж байгаа бол 27.6% буюу 148 ББСБ гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 8.9% буюу 48 ББСБ дагнан эрхэлж байна.

Хүснэгт 2 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо

| № | Үйл ажиллагааны нэр төрөл | ББСБ-ын тоо | | Өсөлт | |
|---|--|-------------|--------|-------|---------|
| | | 2017-И | 2018-И | тоо | хувь |
| | Нийт ББСБ | 529 | 537 | 8 | 1.5% |
| 1 | Зээл | 475 | 486 | 11 | 2.3% |
| | Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг | 353 | 359 | 6 | 1.7% |
| 2 | Факторингийн үйлчилгээ | 22 | 21 | -1 | -4.5% |
| 3 | Төлбөрийн баталгаа гаргах | 13 | 17 | 4 | 30.8% |
| 4 | Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | 2 | 2 | 0 | 0.0% |
| 5 | Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга | 12 | 18 | 6 | 50.0% |
| 6 | Гадаад валютын арилжаа | 146 | 148 | 2 | 1.4% |
| | Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг | 51 | 48 | -3 | -5.9% |
| 7 | Итгэлцлийн үйлчилгээ | 27 | 28 | 1 | 3.7% |
| 8 | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 2 | 8 | 6 | 3 дахин |
| 9 | Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх | 30 | 32 | 2 | 6.7% |


2018 оны I улиралд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ-уудын хувьд зээлийн үйл ажиллагааны 5, гадаад валютын арилжааны 1 тусгай зөвшөөрөл авсан бөгөөд, үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд зээл болон цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээний 3, гадаад валютын арилжаа 2, төлбөрийн баталгаа гаргах, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх 1 тусгай зөвшөөрөл нэмж авчээ. Мөн зээлийн үйл ажиллагаа 3, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх 1 тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон ба зээл, факторинг, гадаад валют арилжаа ба хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тус тус 1 үйл ажиллагааг түдгэлзүүлж 1 ББСБ-ын зээлийн үйл ажиллагааг сэргээсэн байна.

1.2 Статистик үзүүлэлтүүд

2018 оны I улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 537 ББСБ-аас 96.1% буюу 516 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд дор дурдсан нэр бүхий 21 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан байна.

2018 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 5711 хувь нийлүүлэгчдийн 537 ББСБ 177 салбар нэгж, 4 төлөөлөгчийн газар, 2511 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,358,693 харилцагчдад хүрч үйлчилж байна.

Зураг 3 Харилцагч, хувьцаа эзэмшигчид, ажилчдын тоо



Харилцагчид

Нийт харилцагчдын 49.0% нь эмэгтэй, 50.9% нь эрэгтэй, 0.1% нь хуулийн этгээд байна. 89.9 хувийг 2 ББСБ-ын харилцагчид бүрдүүлж байна.

Хүснэгт 3 Харилцагчид 2018-И

| | ББСБ тоо | Хувь | Харилцагчдийн тоо | Хувь |
|--------------------|------------|---------------|-------------------|---------------|
| 100-аас доош | 386 | 71.9% | 13,193 | 1.0% |
| 100-1000 | 116 | 21.6% | 27,584 | 2.0% |
| 1001-10,000 | 32 | 6.0% | 86,708 | 6.4% |
| 10,000-1,000,000 | 2 | 0.4% | 50,772 | 3.7% |
| 1,000,000-аас дээш | 1 | 0.2% | 1,180,436 | 86.9% |
| НИЙТ | 537 | 100.0% | 1,358,693 | 100.0% |

Хувьцаа эзэмшигчид

2018 оны I улирлын байдлаар 537 ББСБ-ын 5711 хувьцаа эзэмшигч байна. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийг оролцуулалгүйгээр 1048 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байгаа ба энэ нь ББСБ-уудын 2017 оны жилийн эцсийн дүнгээс 0.9 хувиар өссөн, 2017 оны I улирлаас 4.6 хувиар буурсан үзүүлэлт юм. Статистик мэдээгээр ХХК-ийн 1048 хувьцаа эзэмшигчдийн 36.4% буюу 381 нь ХК-ийн 4663 хувьцаа эзэмшигчдийн 66.8% буюу 3113 нь эмэгтэй хүн байна.

Нийт 537 ББСБ-ын 299 нь 1 хувьцаа эзэмшигчтэй байгаа бол 238 нь 2 ба түүнээс дээш тооны хувь нийлүүлэгчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Ажиллагсад

537 ББСБ-д 2511 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 16.8 хувь буюу 361 ажилтнаар оны эхнээс 1.5 хувь буюу 38 ажилтнаар нэмэгдсэн дүн юм. Нийт ажилчдын 55.2% буюу 1387 нь эмэгтэй 1124 нь эрэгтэй ажилчид байгаа нь хүйсийн тэнцвэртэй байдлыг харуулж байна.

Одоо үйл ажиллагаа эрхэлж байгаа 537 ББСБ-уудын 21.6% нь буюу 116 ББСБ оноосон нэрэндээ finance, financial гэх үгийг, 15.1% буюу 81 ББСБ capital гэсэн үгийг галиглан ашигласан байдаг байна.

Хүснэгт 4 Ерөнхий статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

| Үзүүлэлтүүд | 2017-I | 2017-IV | 2018-I |
|--------------------------------------|--------|---------|---------|
| Нийт хөрөнгө | 798.3 | 969.2 | 1,046.8 |
| Банкны салбартай харьцуулахад хувиар | 3.2% | 3.4% | 3.6% |
| Нийт өөрийн хөрөнгө | 635.5 | 758.2 | 811.3 |
| Банкны салбартай харьцуулахад хувиар | 19.5% | 24.1% | 25.6% |
| Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө | 509.8 | 595.4 | 645.5 |
| Банкны салбартай харьцуулахад хувиар | 83.4% | 89.9% | 97.1% |
| Нийт зээл | 502.4 | 638.0 | 706.7 |
| Банкны салбартай харьцуулахад хувиар | 4.1% | 4.7% | 5.0% |
| Нийт орлого | 45.2 | 195.9 | 56.8 |

| | | | |
|--------------|------|-------|------|
| Нийт зарлага | 32.3 | 129.1 | 38.5 |
| Цэвэр ашиг | 12.9 | 66.8 | 18.2 |


2018 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө анх удаа 1 их наяд төгрөг давсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.1 хувиар буюу 248.5 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 8 хувиар буюу 77.6 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм. Энэхүү өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар буюу 135.7 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 8.4 хувиар буюу 50.1 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Активын өсөлттэй холбоотойгоор нийт ББСБ-уудын 90.5% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа зээлийн өрийн эцсийн үлдэгдэл нь 2018 оны I улирлын байдлаар 706.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 40.7% буюу 204.3 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 10.8% буюу 68.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 25.7 хувиар буюу 11.6 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 19.2 хувиар буюу 6.2 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 41.1 хувиар буюу 5.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Програм ашиглалт

2018 оны I улирлын байдлаар 537 ББСБ-ын 326 нь буюу 61% нь санхүүгийн програмтай үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 461 ББСБ-ын 292 нь буюу 63%, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 76 ББСБ-ын 45% нь санхүүгийн програмтай байна.

Зураг 4 Санхүүгийн програм ашиглалт



Хамгийн нийтлэг ашиглаж байгаа санхүүгийн програм нь “Ай Би Ай” ХХК-ийн Спинел болон Даймонд програм, “Грейпсити” ХХК-ийн Ачидбанкир болон MARS програмууд байна.

Зураг 5 Програмын төрлүүд /програмтай ББСБ-уудын хувьд/

| Програмын нэр | ББСБ тоо | Эзлэх хувь |
|-------------------------------|------------|---------------|
| IBI - Diamond, Spinel | 130 | 39.9% |
| Ггаре city - Ачидбанкир, Марс | 81 | 24.8% |
| Бусад | 59 | 18.1% |
| ECM - E-FINANCE | 22 | 6.7% |
| RS BANK | 13 | 4.0% |
| EXCEL.MN | 13 | 4.0% |
| ЭЛЕКТРОМОН | 8 | 2.5% |
| Нийт | 326 | 100.0% |

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.8% буюу 461 ББСБ, салбаруудын 70.1% буюу 124 салбар байршиж байна. Үүний 67.5% буюу 311 ББСБ Сүхбаатар болон Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Налайх дүүрэгт 1 ББСБ, 2 салбар, Багахангай дүүрэгт банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Зураг 6 Улаанбаатар хотын ББСБ-ууд болон салбаруудын тархалт



Нийт 3 ББСБ-ын 4 төлөөлөгчийн газар бүртгэлтэй байгаа ба Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Баянгол дүүрэг, Булган аймгийн Булган сум болон Америкийн Нэгдсэн улсын Вашингтон хотод тус тус байршиж байна.

Хүснэгт 5 ББСБ-уудын тархалт /хот/

| Дүүрэг | ББСБ | Салбар | Нийт | Эзлэх хувь |
|-------------------|------------|------------|------------|---------------|
| Сүхбаатар | 164 | 16 | 180 | 30.8% |
| Чингэлтэй | 147 | 21 | 168 | 28.7% |
| Баянгол | 64 | 29 | 93 | 15.9% |
| Баянзүрх | 44 | 34 | 78 | 13.3% |
| Хан-Уул | 29 | 8 | 37 | 6.3% |
| Сонгинохайрхан | 10 | 10 | 20 | 3.4% |
| Багануур | 2 | 4 | 6 | 1.0% |
| Налайх | 1 | 2 | 3 | 0.5% |
| Багахангай | 0 | 0 | 0 | 0.0% |
| НИЙТ /хот/ | 461 | 124 | 585 | 100.0% |

Орон нутагт нийт ББСБ-ын 14.2% буюу 76 ББСБ, салбаруудын 29.9% буюу 53 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 6 ББСБ-уудын тархалт /орон нутаг, бүсээр/

| Бүс | ББСБ | Салбар | Нийт | Эзлэх хувь |
|--------------------------|-----------|-----------|------------|---------------|
| Хангайн бүс | 24 | 22 | 46 | 35.7% |
| Төвийн бүс | 22 | 15 | 37 | 28.7% |
| Зүүн бүс | 13 | 6 | 19 | 14.7% |
| Баруун бүс | 11 | 4 | 15 | 11.6% |
| Говийн бүс | 6 | 6 | 12 | 9.3% |
| НИЙТ /орон нутаг/ | 76 | 53 | 129 | 100.0% |

Нийт 59 ББСБ-ын 177 салбар бүртгэлтэй байгаа ба үүний 36.7 хувийг 5 ББСБ-ын 65 салбар бүрдүүлж байгаа бол 6-9 салбартай 4 ББСБ, 2-5 салбартай 17 ББСБ, 1 салбартай 33 ББСБ Улаанбаатар хотын 8 дүүрэг, Монгол улсын 14 аймагт үйл ажиллагаа явуулж байна.

2. Активын бүтэц, зээлийн үйл ажиллагаа

2.1 Активын бүтэц, түүний өөрчлөлт

2018 оны I улиралд ББСБ-уудын актив 1.0 их наяд 47 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 31.1% буюу 248.5 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 8.0% буюу 77.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 7 Активын бүтэц /сая төгрөгөөр/

| Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/ | 2017-I дүн | 2017-IV дүн | 2018-I дүн | Өөрчлөлт | | | |
|---|----------------------|-------------------|---------------------|---------------------------------------|-------------|--------------------------------|--------------|
| | | | | өмнөх оны мөн үе /2017-I/ дүн хувь | | оны эхэн /2017-IV/ дүн хувь | |
| Эргэлтийн хөрөнгө | 762,644.72 | 932,691.58 | 1,008,583.26 | 75,891.69 | 8.1% | 245,938.55 | 32.2% |
| Мөнгөн хөрөнгө | 227,011.03 | 264,057.75 | 264,170.99 | 113.24 | 0.0% | 37,159.96 | 16.4% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр) | 2,944.27 | 2,742.65 | 1,773.97 | (968.68) | -35.3% | (1,170.30) | -39.7% |
| Зээл (цэврээр) | 456,582.71 | 582,002.00 | 647,868.92 | 65,866.92 | 11.3% | 191,286.22 | 41.9% |
| Факторингийн тооцооны авлага (цэврээр) | 7.80 | 125.00 | 125.00 | - | 0.04% | 117.21 | 16 дахин |
| Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр) | 5,415.55 | 8,110.65 | 8,878.10 | 767.44 | 9.5% | 3,462.55 | 63.9% |
| Бусад хөрөнгө | 70,683.36 | 75,653.52 | 85,766.28 | 10,112.76 | 13.4% | 15,082.92 | 21.3% |
| Эргэлтийн бус хөрөнгө | 35,666.23 | 36,487.42 | 38,188.94 | 1,701.52 | 4.7% | 2,522.71 | 7.1% |
| Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр) | 35,666.23 | 36,487.42 | 38,188.94 | 1,701.52 | 4.7% | 2,522.71 | 7.1% |
| Нийт хөрөнгийн дүн | 798,310.94228 | 969,179.00 | 1,046,772.20 | 77,593.21 | 8.0% | 248,461.26 | 31.1% |

Салбарын нийт активын 96.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.6 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна. Эргэлтийн хөрөнгө оны эхнээс 32.2% буюу 245.9 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 8.1% буюу 75.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт активын 87.1% буюу 912.0 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө болон цэвэр зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 320 ББСБ нийт активын 52.5 хувийг, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 32 ББСБ нийт активын 39.7 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 185 ББСБ нийт активын 7.8 хувийг эзэлж байна.

Активын гол өөрчлөлтүүдийг харвал цэвэр зээлийн үлдэгдэл оны эхнээс 11.3% буюу 65.9 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 41.9% буюу 191.3 тэрбум төгрөгөөр, мөнгөн хөрөнгө оны эхнээс 0.04% буюу 113.2 тэрбум төгрөгөөр,

өмнөх оны мөн үеэс 16.4% буюу 37.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Хүснэгт 8 Нийт актив интервалаар /тэрбум төгрөгөөр/

| Интервал | ББСБ тоо | Дүн | Эзлэх хувь |
|--------------------------|------------|---------------|-------------|
| 1 тэрбумаас доош | 185 | 81.4 | 7.8% |
| 1-4.9 тэрбум хүртэл | 320 | 549.4 | 52.5% |
| 5 тэрбум ба түүнээс дээш | 32 | 416.0 | 39.7% |
| НИЙТ | 537 | 1046.8 | 100% |

- Мөнгөн хөрөнгө

Нийт активын 25.2% буюу 264.2 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Үүнээс 152.8 тэрбум төгрөг буюу мөнгөн хөрөнгийн 57.8% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 65.8 тэрбум буюу 24.9% нь банк болон санхүүгийн байгууллагын харилцах дансанд, 45.6 тэрбум буюу 17.3% нь хадгаламжид байршиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэлэн мөнгө 19.1 хувиар, хадгаламж 36.0 хувиар, харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө 0.9 хувиар өссөн байна.

Зураг 7 Мөнгөн хөрөнгө /сүүлийн 5 жилээр/



- Богино хугацаат хөрөнгө оруулалт


2018 оны I улирлын байдлаар богино хугацаат хөрөнгө оруулалт нь нийт активын 0.2 хувийг бүрдүүлж байна. 19 ББСБ 1.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүний 88.9% буюу 1.6 тэрбум төгрөгийг 4 ББСБ-ын 290.0 сая төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт, 7.1% буюу 126.5 сая төгрөгийг 5 ББСБ-ын 5.0-69.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, үлдсэн 4 хувийг 10 ББСБ-ын тус бүр 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Цэвэр богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн оны эхнээс 39.7% буюу 1.2 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 35.3% буюу 968.9 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарчээ.

Зураг 8 Богино хугацаат хөрөнгө оруулалт /сая.төг/



Арилжааны үнэт цаасанд 42.4% буюу 753.2 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын үнэт цаасанд 57.6% буюу 1024.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Зураг 9 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /2018 оны I улирал/



Богино хугацаат хөрөнгө оруулалтын 77.9 хувийг хувьцаагаарх, 20.7 хувийг Засгийн газрын бондоор, 1.1 хувийг өрийн бичгээрх үлдсэн 0.3 хувийг бусад хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

- Факторингийн тооцооны авлага, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө, бусад хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө

Өмчлөх бусад хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөгөөр өсөж 2.4 тэрбум төгрөгт, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө 3.8 тэрбум төгрөгөөр өсөж 9.8 тэрбум төгрөгт хүрч тэдгээрт нийт 3.3 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Бусад хөрөнгө оны эхнээс 13.4% буюу 10.1 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 21.4% буюу 15.1 тэрбум төгрөгөөр өсөж 85.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 8.2 хувийг бүрдүүлж байна. 2018 оны I улирлын байдлаарх бусад хөрөнгийн 48.7 хувийг хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 28.2 хувийг цэвэр авлага, 23.1 хувийг бусад актив бүрдүүлж байна.

Зураг 10 Бусад хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 537 ББСБ-ын 47.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөнд 9.1 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 9 Үндсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2017-I | 2018-I | Өөрчлөлт | |
|---|-------------|-------------|------------|-------------|
| | | | Дүн | Хувь |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 43.1 | 47.3 | 4.2 | 9.8% |
| Барилга байгууламж | 14.9 | 16.4 | 1.5 | 10.0% |
| Техник хэрэгсэл | 14.0 | 17.0 | 3.0 | 21.4% |
| Тавилга эд хогшил | 5.3 | 6.0 | 0.7 | 12.9% |
| Дуусаагүй барилга | 4.4 | 3.6 | -0.8 | -18.4% |
| Биет бус хөрөнгө | 4.4 | 4.2 | -0.2 | -3.6% |
| Хуриртлагдсан элэгдэл | -7.4 | -9.1 | -1.7 | 22.7% |
| Барилга байгууламжийн | 0.8 | 1.2 | 0.5 | 63.7% |
| Техник хэрэгслийн | 4.8 | 5.7 | 0.9 | 19.6% |
| Тавилга эд хогшлын | 1.9 | 2.2 | 0.3 | 14.0% |
| ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР) | 35.7 | 38.2 | 2.5 | 7.1% |

2.2 Зээл


2018 оны I улирлын байдлаар 486 ББСБ нь 706.7 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй, 137,530 зээлдэгчид зээлийн үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь нийт активын 67.5%, эргэлтийн хөрөнгийн 70.1 хувийг бүрдүүлж байна.

2.2.1 Зээлийн зориулалт

2017 оны жилийн эцэст 482 ББСБ-ын 637.7 тэрбум төгрөгийн /638.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 1 ББСБ нэгдсэн, 1 ББСБ хүчингүй болсон/ зээлийн үлдэгдэлтэй байсан ба 2018 оны I улиралд 398 ББСБ нийт 290.3 тэрбум

төгрөгийн зээл олгосон бол 428 ББСБ-ын 221.2 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж 2018 оны I улирлын байдлаар 470 ББСБ-ын 706.7 тэрбум төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэлтэй гарчээ.

Зураг 11 Олгосон болон төлөгдсөн зээл /хуулийн этгээд, иргэн/



Олгосон зээлийн 81.6% буюу 236.9 тэрбум төгрөгийг иргэдэд олгосон бол 18.4% буюу 181.5 тэрбум төгрөгийг хуулийн этгээдэд олгосон байна.

Олгосон болон төлөгдсөн зээлийг авч үзвэл, хэрэглээний зээлд 158.4 сая төгрөгийн зээл олгож, 114.8 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн, худалдааны салбарт 52.2 тэрбум төгрөгийн зээл олгож, 42.9 төгрөгийн зээл эргэн төлөгджээ.

Зураг 12 Олгосон болон төлөгдсөн зээл /салбараар/




2.2.2 Зээлийн багцын чанар

Хүснэгт 10 Зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/

| Зээлийн чанарын ангилал /тэрбум төгрөгөөр/ | 2017-I | 2017-IV | 2018-I | Өөрчлөлт | |
|--|--------------|--------------|--------------|---------------|-----------------------|
| | | | | оны эхэн хувь | өмнөх оны мөн үе хувь |
| Хэвийн | 404.8 | 527.0 | 590.5 | 12.0% | 45.9% |
| Хугацаа хэтэрсэн | 30.1 | 29.9 | 37.9 | 26.8% | 26.0% |
| Чанаргүй: | 67.5 | 81.1 | 78.3 | -3.4% | 16.1% |
| Хэвийн бус | 15.1 | 17.6 | 17.1 | -2.8% | 13.1% |
| Эргэлзээтэй | 16.9 | 14.2 | 16.5 | 15.9% | -2.2% |
| Муу | 35.5 | 49.3 | 44.8 | -9.2% | 26.1% |
| (Зээлийн эрсдэлийн сан) | 45.8 | -56.0 | -58.9 | 5.1% | -228.6% |
| Нийт зээл | 502.4 | 638.0 | 706.7 | 10.8% | 40.7% |
| ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР) | 456.6 | 582.0 | 647.9 | 11.3% | 41.9% |
| Нийт зээл (төгрөгийн) | 463.3 | 605.3 | 669.0 | 10.5% | 44.4% |
| Нийт зээл (валютын) | 39.1 | 32.7 | 37.8 | 15.5% | -3.3% |


Нийт зээлийн 590.5 тэрбум төгрөг буюу 83.5 хувийг хэвийн зээл, 37.9 тэрбум төгрөг буюу 5.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 78.3 тэрбум төгрөг буюу 11.1 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба чанаргүй зээлийн 75.2 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна. Чанаргүй зээлийн хэмжээ оны эхнээс 3.4 хувиар буюу 2.74 тэрбум төгрөгөөр буурсан бол хэвийн зээл 12.0% буюу 63.45 тэрбум төгрөгөөр, хугацаа хэтэрсэн зээл 26.8% буюу 8.03 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 13 Зээлийн чанар /хувиар/



Оны эхэнтэй харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 1.6 функтээр буурч, хугацаа хэтэрсэн болон хэвийн зээлийн хэмжээ харгалзан 0.7 болон 0.9 функтээр өссөн үзүүлэлттэй гарчээ.

Зураг 14 Төгрөгийн болон гадаад валютын зээлийн харьцаа



Нийт зээлийн эцсийн үлдэгдэлд эзлэх валютын зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 функтээр буурсан бол оны эхэнтэй харьцуулахад 0.2 функтээр өссөн дүнтэй гарчээ.

2.2.3 Зээлдэгчид

Хүснэгт 11 Ерөнхий статистик /харилцагчид/


| Харилцагчдын мэдээлэл | Дүн | Хувь |
|-------------------------------|------------------|---------------|
| Нийт харилцагчдын тоо | 1,358,693 | 100.0% |
| Үүнээс: Эмэгтэй | 665,623 | 49.0% |
| Хуулийн этгээд | 1,189 | 0.1% |
| Зээлдэгчдийн тоо | 137,530 | 100.0% |
| Хэвийн | 123,985 | 90.2% |
| Хугацаа хэтэрсэн | 7,487 | 5.4% |
| Чанаргүй: | 6,058 | 4.4% |
| Хэвийн бус | 1,672 | 1.2% |
| Эргэлзээтэй | 1,195 | 0.9% |
| Муу | 3,191 | 2.3% |
| Зээлдэгчдийн насжилт | 136,628 | 100.0% |
| 18-35 насны | 63,282 | 46.3% |
| 36-45 насны | 43,557 | 31.9% |
| 46-55 насны | 21,638 | 15.8% |
| 55-аас дээш | 8,151 | 6.0% |
| Зээлдэгчдийн боловсрол | 136,627 | 100.0% |
| -Дээд | 73,503 | 53.8% |
| -Тусгай дунд | 15,699 | 11.5% |
| -Бүрэн дунд | 33,535 | 24.5% |
| -Дунд | 6,317 | 4.6% |
| -Бага | 7,573 | 5.5% |

2018 оны I улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 486 ББСБ-ын 137,530 зээлдэгч бүртгэлтэй байгаа бөгөөд тэдгээрийн 90.2% буюу

123,985 нь хэвийн, 5.4% буюу 7,487 хугацаа хэтэрсэн, 1.2% буюу 1,672 нь хэвийн бус, 0.9% буюу 1,195 нь эргэлзээтэй, 2.3% буюу 3,191 муу зээлдэгчид байна.

Насжилтын хувьд авч үзвэл нийт зээлдэгчдийн 78.2% буюу 106,839 нь 18-45 насны, 15.8% буюу 21,638 нь 46-55 насны, 6.0% буюу 8,151 нь 55-аас дээш насны иргэд байна.

Зураг 15 Зээлдэгчдийн боловсрол




Боловсролын төвшнөөр дээд болон тусгай дунд боловсролтой иргэд нийт зээлдэгчдийн 89,202 буюу 65.3 хувийг бүрдүүлж байгаа бол бүрэн дунд боловсролтой иргэд 333,535 буюу 24.5 хувийг, бага болон дунд боловсролтой иргэд 13,890 буюу 10.2 хувийг бүрдүүлж байна.

2.2.4 Зээлийн жигнэсэн дундаж хүү

2018 оны I улирлын байдлаар зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 486 ББСБ-аас 398 ББСБ 290.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд олгосон зээлийн дээд хүү 10.0%, доод хүү 1.3%, жигнэсэн дундаж хүү 3.4% байна.

/6 ББСБ-ын хүүг 2017 оны IV улирлын байдлаар тооцсон болно./

Зураг 16 Зээлийн жигнэсэн дундаж хүү



ББСБ-уудын зээлийн жигнэсэн дундаж хүү 3.4%-тай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 пунктээр буусан үзүүлэлт юм. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.8 пунктээр өндөр гарсан байна.

3. Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт хөрөнгийн 22.5% буюу 235.5 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 77.5% буюу 811.3 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. Харин өр төлбөрийн 53.9% буюу 126.8 тэрбум төгрөгийг банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 17.9% буюу 42.2 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээний өглөг эзэлж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн 79.6% буюу 645.5 тэрбум төгрөгийг хувьцаат капитал, 19.0% буюу 154.5 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг эзэлж байна.

2018 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Хүснэгт 12 Пассивын бүтэц /сая төгрөгөөр/

| Хөрөнгө | 2017-I | 2017-IV | 2018-I | Өөрчлөлт | | | |
|--|-------------------|-------------------|---------------------|-----------------|-------------|--------------------|--------------|
| | | | | Оны эхнээс | | Өмнөх оны мөн үеэс | |
| | | | | Тоогоор | Хувиар | Тоогоор | Хувиар |
| Өр төлбөр | 162,788.9 | 211,011.1 | 235,455.1 | 24,444.0 | 11.6% | 72,890.2 | 44.8% |
| Санхүүгийн эх үүсвэр | 32,287.2 | 39,217.7 | 42,229.0 | 3,011.3 | 7.7% | 9,941.9 | 30.8% |
| Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг | 62,703.2 | 112,761.7 | 126,821.3 | 14,059.6 | 12.5% | 64,118.1 | 102.3% |
| Бусад эх үүсвэр | 4,918.1 | 6,711.2 | 9,603.8 | 2,892.6 | 43.1% | 4,685.7 | 95.3% |
| Ббсб-аас гаргасан өрийн бичиг | 3,971.1 | 6,876.9 | 9,914.0 | 3,037.1 | 44.2% | 5,942.8 | 149.7% |
| Төслийн зээлийн санхүүжилт | 36,041.0 | 14,869.9 | 16,446.1 | 1,576.2 | 10.6% | -19,384.9 | -54.1% |
| Бусад өр төлбөр | 22,868.3 | 30,573.7 | 30,441.0 | (132.7) | -0.4% | 7,586.6 | 33.2% |
| Эздийн өмч | 635,522.1 | 758,167.9 | 811,317.1 | 53,149.2 | 7.0% | 178,119.7 | 28.1% |
| Хувьцаат капитал | 509,779.1 | 595,389.1 | 645,504.3 | 50,115.2 | 8.4% | 136,835.3 | 26.9% |
| Бусад өмч | 6,526.1 | 6,570.8 | 10,145.9 | 3,575.2 | 54.4% | 3,619.9 | 55.5% |
| Сангууд | 565.1 | 429.6 | 463.5 | 33.8 | 7.9% | -101.6 | -18.0% |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | 117,745.3 | 155,071.8 | 154,536.8 | (535.0) | -0.3% | 38,006.2 | 32.6% |
| Хоёрдогч өглөг | 906.6 | 706.6 | 666.6 | (40.0) | -5.7% | -240.0 | -26.5% |
| Нийт өр төлбөр ба эздийн өмч | 798,311.00 | 969,179.00 | 1,046,772.20 | 77,593.2 | 8.0% | 251,009.89 | 31.5% |

3.1 Өр төлбөр

ББСБ-ын өр төлбөрийн хэмжээ 2018 оны I улиралд өмнөх оны мөн үеэс 72.9 тэрбум төгрөгөөр буюу 44.8 хувиар, оны эхнээс 24.4 тэрбум төгрөгөөр буюу 11.6 хувиар өсөж нийт пассивын 235.5 тэрбум төгрөг хүрсэн байна.


- Итгэлцлийн үйлчилгээний өглөг

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 28 ББСБ-ын 22 нь 2017 онд 42.2 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр эх үүсвэр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт пассивын 4.0 хувьтай тэнцэж байна.

4 ББСБ 100 сая төгрөг хүртэлх дүнгээр 165.0 сая төгрөгийн, 8 ББСБ 100 сая-1 тэрбум хүртэлх дүнгээр 4.8 тэрбум төгрөгийн, 1 тэрбум төгрөгөөс дээш 10 ББСБ 37.2 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн 42.2 тэрбум төгрөгийн 83.6% буюу 35.3 тэрбум төгрөгийг 21 ББСБ төгрөгөөр, 16.4% буюу 6.9 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 10 ББСБ валютаар татан төвлөрүүлсэн байна.

Зураг 17 Итгэлцлийн үйлчилгээний өглөг



- Дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2018 оны I улирлын байдлаар 69 ББСБ дотоод гадаадын банк, санхүүгийн байгууллагын 126.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт хөрөнгийн 12.1 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 64.1 тэрбум төгрөгөөр буюу 1 дахин, оны эхнээс 14.1 тэрбум төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн үзүүлэлт юм.

Банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн 69.3 хувийг дотоодын, 30.7 хувийг гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл эзэлж байна. Дотоодын банк санхүүгийн байгууллагуудаас 66 ББСБ 87.8 тэрбум төгрөг, гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас 8 ББСБ 39.0 тэрбум төгрөгийн зээл татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 13 Дотоодын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

| Авсан зээлийн хэмжээ | ББСБ-ын тоо | Нийт зээлд эзлэх хувь | Зээлийн хэмжээ |
|----------------------|-------------|-----------------------|----------------|
| 1 тэрбумаас дээш | 18 | 85.08% | 77.8 |
| 0.1-0.9 тэрбум | 30 | 13.62% | 9.3 |
| 0.1 тэрбумаас доош | 18 | 1.30% | 0.7 |
| НИЙТ | 66 | 100.00% | 87.8 |

Хүснэгт 14 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээл /тэрбум төгрөгөөр/

| Авсан зээлийн хэмжээ | ББСБ тоо | Нийт зээлд эзлэх хувь | Зээлийн хэмжээ |
|----------------------|----------|-----------------------|----------------|
| 10 тэрбумаас дээш | 1 | 61.19% | 23.9 |
| 1-9 тэрбум | 3 | 35.93% | 14 |
| 1 тэрбумаас доош | 5 | 2.88% | 1.1 |
| НИЙТ | 9 | 100% | 39 |

- Бусад эх үүсвэр

Бусад эх үүсвэр нийт пассивын 0.9% буюу 9.6 тэрбум төгрөгийг бүрдүүлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 95.3% буюу 4.7 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 43.1% буюу 2.9 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ.

2018 оны I улирлын байдлаар бусад эх үүсвэрийн 68.3% буюу 6.6 тэрбум төгрөгийг нийт цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээний үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 18 ББСБ-аас 8 ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй гарчээ.

Зураг 18 Бусад эх үүсвэрийн бүтэц



- ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2018 оны I улирлын байдлаар 11 ББСБ 9.9 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан нь өмнөх оны мөн үеэс 2.5 дахин буюу 5.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 44.2% буюу 3.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Энэ өсөлтөд 11 ББСБ-ын нэмж гаргасан 8.9 тэрбум төгрөгийн төгрөгөөрх, 1.0 тэрбум төгрөгийн валютаарх өрийн бичгүүдийн өсөлт нөлөөлсөн байна.


- Төслийн зээл санхүүжилт

2018 оны I улиралд 40 ББСБ 16.4 тэрбум төгрөгийн төслийн зээлтэй байгаа нь нийт хөрөнгийн 1.6 хувийг эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 54.4% буюу 19.6 тэрбум төгрөгөөр буурсан бол оны эхнээс 10.6% буюу 1.6 тэрбум төгрөгөөр өсжээ.

Төслийн санхүүжилтийн 62.2% буюу 10.2 тэрбум төгрөгийг төгрөгийн, 37.8% буюу

6.2 тэрбум төгрөгийг валютын зээл эзэлж байна.

Зураг 19 Төслийн зээлийн санхүүжилт /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат санхүүжилтээр 15 ББСБ 3.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байгаа бол урт хугацаат санхүүжилтээр 28 ББСБ 13.0 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан байна.

Төслийн зээлийн 8.3 тэрбум төгрөгийг гадаад байгууллагаас, 6.3 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас, 0.84 тэрбум төгрөгийг Засгийн газрын төслийн зээлийн эх үүсвэрээс 1.03 тэрбум төгрөгийг бусад санхүүжилтээс бүрдүүлсэн байна.

- Бусад өр төлбөр

2018 оны I улирлын байдлаар 480 ББСБ 30.4 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь нийт пассивын 2.9 хувийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 33.1% буюу 7.6 тэрбум төгрөгөөр өссөн, оны эхнээс 0.4% буюу 132.7 сая төгрөгөөр буурсан дүн байна.

Бусад өр төлбөрийн 78.6% буюу 23.9 тэрбум төгрөгийг бусад пассив, 21.4% буюу 6.5 тэрбум төгрөгийг хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг бүрдүүлж байна.

Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг болон бусад пассивын задаргаа:

Зураг 20 Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг



Бусад пассивын задаргаа:

Зураг 21 Бусад пассив /сая төгрөгөөр/




3.2 Эздийн өмч

Сүүлийн 5 жилийн I улирлын байдлаар

нийт ББСБ-уудын өр төлбөр нийт хөрөнгийн хэмжээнд эзлэх хувь хэмжээ буурсан бөгөөд энэ нь ББСБ-ууд өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж байгаатай холбоотой. ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хэмжээ 2017 оны I улиралд 63.9 хувийг бүрдүүлж байсан бол 2018 оны I улиралд 61.7 хувийг бүрдүүлж байна.

Зураг 22 Пассивын бүтэц /тэрбум төгрөгөөр/



2016-2017 оны I улирлын хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт нь 49.1%-тай байсан бол 2017-2018 оны I улиралд 26.9 хувийн өсөлт үзүүлсэн байна. Өсөлт буурсан шалтгаан нь 2016-2017 оны I улиралд дунджаар 520.2 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байсан ББСБ-ууд дунджаар 421.4 сая төгрөгөөр буюу 81 хувиар хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн бол 2017-2018 оны I улиралд дунджаар 921.7 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ББСБ-ууд дунджаар 288.0 сая төгрөгөөр буюу 31.2 хувиар хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна.

2018 оны I улиралд 168 ББСБ хувь нийлүүлсэн хөрөнгөө 44.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бол 1 ББСБ 75.0 сая төгрөгөөр хорогдуулсан байна.

2018 оны I улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 58 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 35.3 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.4-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 284 ББСБ 52.1 хувийг эзэлж

байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 195 ББСБ 12.7 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 15 Хувь нийлүүлсэн хөрөнгө /интервалаар/

| Интервал | ББСБ тоо | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь |
|--------------------------|------------|---------------|--------------|---------------|
| 0.9 тэрбумаас доош | 195 | 36.3% | 81.8 | 12.7% |
| 1.4-1.8 тэрбум хүртэл | 257 | 47.9% | 279.6 | 43.3% |
| 1.9-2.4 тэрбум хүртэл | 27 | 5.0% | 56.4 | 8.7% |
| 2.5-4.9 тэрбум хүртэл | 46 | 8.6% | 136.5 | 21.1% |
| 5 тэрбум ба түүнээс дээш | 12 | 2.2% | 91.2 | 14.1% |
| НИЙТ | 537 | 100.0% | 645.5 | 100.0% |

4. Орлого, үр дүнгийн тайлан

2018 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 56.8 тэрбум төгрөгийн орлоготой, 38.5 тэрбум төгрөгийн зарлагатай 18.2 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.


Зураг 23 Ашигт ажиллагааны үзүүлэлт



4.1 Орлого

2018 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.6% буюу 11.6 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарчээ. Хүүгийн орлого 10.59 тэрбум төгрөгөөр, хүүгийн бус орлого 0.51 тэрбум төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлого 0.50 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 24 Орлогын бүтэц /тэрбум төгрөгөөр/



• Хүүгийн орлого

Хүүгийн орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 28.5 хувиар буюу 10.6 тэрбум төгрөгөөр өсөж нийт орлогын 84.0% буюу 47.7 тэрбум төгрөгийн дүнтэй гарсан байна.

• Хүүгийн бус орлого

Хүүгийн бус орлого нь 2018 оны I улирлын байдлаар нийт орлогын 12.2% буюу 6.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 7.9% буюу 507.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт байна.

Зураг 25 Хүүгийн бус орлого /тэрбум төгрөгөөр/



Гадаад валют арилжааны орлого 70.3 сая төгрөгөөр нэмэгдэж 968.8 саяд хүрч 7.8 хувийн өсөлт үзүүлсэн бол гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого 1.1 тэрбум төгрөгөөр буурч 1.8 тэрбум төгрөг, санхүүгийн үйлчилгээний орлого 55.4% буюу 1.4 тэрбум төгрөгөөр өссөн эерэг үр дүн үзүүлсэн байна.

Санхүүгийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 55.3% буюу 1.5 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүнд үйлчилгээ хураамж шимтгэлийн орлого 2.1 дахин буюу 1.3 тэрбум төгрөгөөр, мөнгөн гуйвуулгын орлого 2.3 дахин буюу 185.5 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.


Хүснэгт 16 Санхүүгийн үйлчилгээний орлого /сая,төг/

| Төрөл | 2017-I | 2018-I | Өөрчлөлт | |
|--|----------------|----------------|----------------|--------------|
| | | | Дүн | Хувь |
| Итгэлцлийн үйлчилгээний орлого | 0.0 | 2.3 | 2.3 | - |
| Мөнгөн гуйвуулгын орлого | 144.5 | 330.0 | 185.5 | 2.3 дахин |
| Каргын үйлчилгээний орлого | 1.6 | 0.0 | -1.6 | - |
| Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого | 30.0 | 37.2 | 7.2 | 24.1% |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 1,175.0 | 2,499.9 | 1,324.9 | 2.1 дахин |
| Бусад | 1,338.7 | 1,311.6 | -27.1 | -2.0% |
| НИЙТ | 2,689.8 | 4,181.0 | 1,491.2 | 55.4% |

• Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогын 3.8 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 504.8 сая төгрөгийн буюу 30.1 хувийн өсөлттэй байна.

Зураг 26 Үндсэн бус үйл ажиллагааны орлого



4.2 Зарлага

2018 оны I улиралд 38.5 тэрбум төгрөгийн зардалтай гарсан нь өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 19.3 хувиар өссөн үзүүлэлт байна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал буурсан үзүүлэлттэй гарсан бол бусад зардал өссөн дүнтэй гарчээ.

Хүснэгт 17 Зарлагын бүтэц /тэрбум төгрөгөөр/

| ЗАРДЛЫН ТӨРӨЛ | 2017-И | 2018-И | Өөрчлөлт | |
|-----------------------------------|-------------|-------------|------------|--------------|
| | | | Дүн | Хувь |
| Хүүгийн зардал | 4.0 | 4.6 | 0.6 | 16.2% |
| Хүүгийн бус зардал | 20.0 | 21.3 | 1.4 | 7.0% |
| Болзошгүй эрсдэлийн зардал | 5.9 | 9.3 | 3.4 | 57.6% |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 0.7 | 0.7 | -0.1 | -10.0% |
| Орлогын албан татварын зардал | 1.7 | 2.6 | 1.0 | 56.4% |
| Нийт зарлага | 32.3 | 38.5 | 6.3 | 19.6% |

- Хүүгийн зардал

Хүүгийн зардал нийт зардлын 12.0% буюу 4.6 тэрбум төгрөг байна. 2017 оны мөн үеийн дүнтэй харьцуулахад 16.2% буюу 0.6 тэрбумаар өссөн байна.

- Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардал нь 21.3 тэрбум төгрөг буюу нийт зардлын 55.3 хувийг бүрдүүлж байна. 2017 оны мөн үетэй харьцуулахад 6.8% буюу 1.4 тэрбум төгрөгөөр өсжээ.

- Болзошгүй эрсдэлийн зардал

Нийт зардлын 24.1% буюу 9.3 тэрбум төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал бүрдүүлж байгаа ба энэ зардал нь өмнөх оны мөн үеэс 57.6% буюу 3.4 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй гарсан байна. Үүнд зээлийн эрсдэлийн зардал 67.0% буюу 3.5 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Авлагын эрсдэлийн зардал 92.4 сая төгрөгөөр буурч, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал 14.0 сая төгрөгөөр өсжээ.

- Үндсэн бус үйл ажиллагааны зардал


Нийт зардлын 1.7 хувийг үндсэн бус үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 10.0% буюу 72.5 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарчээ.

4.3 Ашигт ажиллагаа

2018 оны I улиралд ББСБ-ууд 18.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 5.3 тэрбум төгрөгөөр буюу 41.1 хувиар өссөн үзүүлэлт юм.

537 ББСБ-ын 421 нь буюу 78.4% нь 24.5 тэрбум төгрөгийн ашигтай, 92 нь буюу 17.1% нь 6.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, 24 нь буюу 4.5% нь үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Зураг 27 Ашигийн өсөлт /хувиар/




5. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2018 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 537 ББСБ-ын 86.0% буюу 462 ББСБ үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 14.0% нь буюу 75 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 54 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 15 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 4 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 0 ББСБ, 5 ба түүнээс дээш зохистой харьцаа алдагдсан 2 ББСБ байна.

Зураг 28 Зохистой харьцаа



5.1 Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 18 Журмын 3.2-т заасан этгээдийн ЗХШУ

| Үзүүлэлт | ББСБ-ын тоо | Эзлэх хувь |
|---------------------------------------|-------------|-------------|
| Зохистой харьцааг бүрэн хангасан | 47 | 92.2% |
| 1 зохистой харьцааг хангаагүй | 1 | 2.0% |
| 2 зохистой харьцааг хангаагүй | 3 | 5.9% |
| 3 зохистой харьцааг хангаагүй | - | - |
| 4 зохистой харьцааг хангаагүй | - | - |
| 5 ба дээш зохистой харьцааг хангаагүй | - | - |
| НИЙТ | 51 | 100% |

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 49 ББСБ хангасан буюу биелэлт 96.1%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 94.1%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага 50 ББСБ хангасан буюу биелэлт 98.0%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн хангасан;
5. Үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлагыг 50 ББСБ хангасан буюу 98.0%;
6. Өөрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Эдгээр 51 ББСБ-уудын хувьд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас

доошгүй байх шалгуур үзүүлэлт хамгийн ихээр алдагдсан байна.

5.2 Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

Хүснэгт 19 Журмын 3.3-т заасан этгээдийн ЗХШУ

| Үзүүлэлт | ББСБ-ын тоо | Эзлэх хувь |
|---------------------------------------|-------------|-------------|
| Зохистой харьцааг бүрэн хангасан | 372 | 85.0% |
| 1 зохистой харьцааг хангаагүй | 50 | 11.4% |
| 2 зохистой харьцааг хангаагүй | 11 | 2.5% |
| 3 зохистой харьцааг хангаагүй | 4 | 0.9% |
| 4 зохистой харьцааг хангаагүй | 0 | 0% |
| 5 ба дээш зохистой харьцааг хангаагүй | 1 | 0.2% |
| НИЙТ | 438 | 100% |

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 433 ББСБ хангасан буюу биелэлт 98.9%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 433 ББСБ хангасан буюу биелэлт 98.9%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 436 ББСБ хангасан буюу биелэлт 99.5%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 423 ББСБ хангасан буюу биелэлт 96.6 хувь;
5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний зөрүү 0 байх шаардлагыг 434 ББСБ хангасан буюу биелэлт 99.1%;
6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 420 ББСБ хангасан буюу биелэлт 95.9%;

7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 429 ББСБ хангасан буюу биелэлт 97.9%;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 434 ББСБ хангасан буюу биелэлт 99.1%;
9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
10. Нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
11. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
12. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага 424 ББСБ хангасан буюу биелэлт 96.8%;
13. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 425 ББСБ хангасан буюу биелэлт 97.0% хувь;
14. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх 438 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 13-18 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

5.3 Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Хүснэгт 20 Журмын 3.4-т заасан этгээдийн ЗХШҮ

| Үзүүлэлт | ББСБ-ын тоо | Эзлэх хувь |
|---------------------------------------|-------------|-------------|
| Зохистой харьцааг бүрэн хангасан | 43 | 89.6% |
| 1 зохистой харьцааг хангаагүй | 3 | 6.3% |
| 2 зохистой харьцааг хангаагүй | 1 | 2.1% |
| 3 зохистой харьцааг хангаагүй | 0 | 0% |
| 4 зохистой харьцааг хангаагүй | 0 | 0% |
| 5 ба дээш зохистой харьцааг хангаагүй | 1 | 2.1% |
| НИЙТ | 48 | 100% |

Журмын 3.4-т заасан хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9%;
2. Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9%;
3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9%;
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 95.8%;
5. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 48 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
6. Нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 95.8%;
7. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 10 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
8. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн зохистой

- харьцааны шалгуур үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
9. Үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
10. Худалдан авах хувьцааны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9%;
11. Нэг компаниас худалдан авах хувьцааны төвлөрлийн үзүүлэлт өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
12. Өрийн бичгийн эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
13. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан байх шаардлага бүрэн;
14. ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
15. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 95.8%;
16. Итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9%;
17. Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг шаардлагыг 46 ББСБ хангасан буюу биелэлт 95.8%;
18. Өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй айх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх 48 хуулийн этгээдийн хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлтүүдийг 2 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

6. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.1 Орон нутаг дахь ББСБ-ууд

- Ерөнхий статистик

Тайлант онд хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 76 ББСБ, 188 хувьцаа эзэмшигч, 183 ажилтан, 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 7942 харилцагч, 6016 зээлдэгчдэд хүрч ажиллаж байна.

Хамгийн олон ББСБ-тай аймгууд нь Төв аймаг 10, Орхон, Дорнод аймгуудад тус тус 7 ББСБ байршиж байна.

Зураг 29 Орон нутгийн ББСБ-ууд, орон нутаг дахь салбаруудын тархалт



Хүснэгт 21 Орон нутгийн ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

| № | Үйл ажиллагааны төрөл | ББСБ тоо |
|-------------|------------------------|-----------|
| 1 | Зээл | 73 |
| 2 | Гадаад валютын арилжаа | 6 |
| 3 | ХОСЧЗМӨ | 3 |
| 4 | Итгэлцлийн үйлчилгээ | 1 |
| 5 | Факторингийн үйлчилгээ | 1 |
| НИЙТ | | 84 |

ББСБ-ын 5 төрлийн 84 тусгай зөвшөөрлийн хүрээнд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. 34 ББСБ буюу 44.7% нь санхүүгийн програмтай байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 91.1% нь хэвийн, 2.0% нь хугацаа хэтэрсэн, 6.9% нь чанаргүй зээлдэгчид байна.

ББСБ-уудын зээлдэгчдийн насжилтаар авч үзвэл орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 72.1 хувийг 18-45 насны,

178.4 хувийг 46-55 насны, 9.5 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлж байна. Боловсролын түвшний хувьд дээд боловсролтой иргэд 41.3%, тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой иргэд 46.5%, бага болон дунд боловсролтой иргэд 12.2 хувийг бүрдүүлж байна.

- Актив

Салбарын нийт активын 2.4 хувийг бүрдүүлж байгаа орон нутгийн ББСБ-уудын 25.1 тэрбум төгрөгийн актив хөрөнгийн 5.0 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 368.6 сая төгрөг нь богино хугацаат хөрөнгө оруулалт цэврээр/, 17.4 тэрбум нь зээл /цэврээр/, 203.1 тэрбум төгрөг нь өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр), 1.4 тэрбум төгрөгийг бусад хөрөнгө, 774.6 сая


төгрөг нь үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр) бүрдүүлж байна.

Хүснэгт 22 Орон нутгийн ББСБ-уудын активын бүтэц

| Тайлангийн үзүүлэлтүүд | Дүн | Хувь |
|---|----------------------|---------------|
| Эргэлтийн хөрөнгө | 24,309,621.84 | 96.9% |
| Мөнгөн хөрөнгө | 4,952,880.42 | 19.7% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр) | 368,590.70 | 1.5% |
| Зээл (цэврээр) | 17,378,848.05 | 69.3% |
| Факторингийн тооцооны авлага (цэврээр) | 0 | 0.0% |
| Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр) | 203,097.13 | 0.8% |
| Бусад хөрөнгө | 1,406,205.54 | 5.6% |
| Эргэлтийн бус хөрөнгө | 774,632.93 | 3.1% |
| Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр) | 774,632.93 | 3.1% |
| Нийт хөрөнгийн дүн | 25,084,254.77 | 100.0% |

Зээлийн хувьд 16.8 тэрбум төгрөгийн хэвийн зээл, 308.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 4.9 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Зээлийн эрсдэлийн санг чанаргүй зээлийн 94.4 хувьд байгуулжээ.

Зураг 30 Орон нутгийн ББСБ-уудын зээлийн бүтэц



2017 онд орон нутгийн банк санхүүгийн байгууллагын үндсэн ба биет бус хөрөнгө цэврээр 774.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

• **Пассив**

Орон нутгийн 76 ББСБ-ын хөрөнгө 25.1 тэрбум төгрөгийн 88.7% буюу 22.2 тэрбум төгрөг нь эздийн өмч, 11.3% буюу 2.8 тэрбум төгрөг нь өр төлбөр байна. Орон нутгийн ББСБ-уудын нийт хөрөнгийн 85.3 хувийг буюу 21.4 тэрбум төгрөгийг хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлж байгаа ба энэ нь салбарын хувьцаат капиталын 3.3 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 23 Орон нутгийн ББСБ пассивын бүтэц

| Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум.төг/ | Дүн | Хувь |
|--|--------------|---------------|
| Өр төлбөр | 2.84 | 11.3% |
| Санхүүгийн эх үүсвэр | 0.98 | 3.9% |
| Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг | 0.50 | 2.0% |
| Төслийн зээлийн санхүүжилт | 0.90 | 3.6% |
| Бусад өр төлбөр | 0.46 | 1.8% |
| Эздийн өмч | 22.24 | 88.7% |
| Хувьцаат капитал | 21.40 | 85.3% |
| Бусад өмч | 0.36 | 1.4% |
| Сангууд | 0.36 | 1.4% |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | 0.12 | 0.5% |
| Нийт өр төлбөр ба эздийн өмч | 25.08 | 100.0% |

• **Орлого үр дүнгийн тайлан**

2017 оны I улиралд орон нутгийн ББСБ-ууд 1.6 тэрбум төгрөгийн орлоготой, 816.1 сая төгрөгийн зарлагатай, 736.4 сая төгрөгийн цэвэр орлоготой ажиллаа. Орлогын 90.9 хувийг хугацаандаа байгаа хүүгийн орлого бүрдүүлж байна. Нийт зардлын 78.0% буюу 636.3 сая төгрөгийг хүүгийн бус зардал /үүнээс боловсон хүчний холбогдолтой зардал 382.9 сая, бусад зардал 252.3 сая/, 6.3% буюу 51.3 сая төгрөгийг болзошгүй эрсдэлийн зардал /үүнээс зээлийн эрсдэлийн зардал 50.9 сая/ эзэлж байна.

6.2 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ууд

• **Ерөнхий статистик**

Хүснэгт 24 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын үйл ажиллагааны төрөл

| Үйл ажиллагааны төрөл | ББСБ-ын тоо |
|--|-------------|
| Зээл | 28 |
| Факторингийн үйлчилгээ | 1 |
| Төлбөрийн баталгаа гаргах | 4 |
| Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | 0 |
| Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 1 |
| Гадаад валютын арилжаа | 12 |
| Итгэлцлийн үйлчилгээ | 2 |
| Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 1 |
| Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх | 3 |
| НИЙТ | 52 |

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай, 11 улсын 38 хувьцаа эзэмшигчийн 28 ББСБ, 8 төрлийн 52 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь салбарын ББСБ-ын тооны 5.2 хувийг эзэлж байна.

- **Актив**

Гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ-ын хөрөнгө 138.9 тэрбум төгрөг нь нийт хөрөнгийн 13.3 хувийг бүрдүүлж байна.

Активын 71.1% буюу 98.8 тэрбум нь зээл, 22.7% буюу 12.0% нь мөнгөн хөрөнгө байгаа бол мөнгөн хөрөнгийн 19.4% буюу 6.1 тэрбум төгрөг нь кассанд, 36.5% буюу 11.3 тэрбум төгрөг нь харилцах дансанд, 44.1% буюу 12.0 тэрбум төгрөг нь хадгаламжийн дансанд тус тус байршиж байна.

- **Пассив**

Пассивын 48.7% буюу 67.6 тэрбум төгрөгийг өр төлбөр, 51.3% буюу 71.2 тэрбум төгрөгийг эздийн өмч эзэлж байна.

Нийт 537 ББСБ-ын пассивын бүтэц нь эздийн өмч давамгайлсан бүтэцтэй байдаг бол гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьд өр төлбөр болон эздийн өмчийн харьцаа ойролцоо дүнтэй байна. Өр төлбөрийн 65.4% нь дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл байгаа бол эздийн өмчийн 84.9% нь хувьцаат капитал байна.

Хүснэгт 25 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын пассив

| Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/ | Дүн | Хувь |
|--|---------------|---------------|
| Өр төлбөр | 67.69 | 48.7% |
| Санхүүгийн эх үүсвэр | 8.29 | 6.0% |
| Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг | 44.25 | 31.9% |
| Бусад эх үүсвэр | 3.52 | 2.5% |
| Төслийн зээлийн санхүүжилт | 7.00 | 5.0% |
| Бусад өр төлбөр | 4.63 | 3.3% |
| Эздийн өмч | 71.23 | 51.3% |
| Хувьцаат капитал | 60.45 | 43.5% |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | 9.54 | 6.9% |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 1.24 | 0.9% |
| НИЙТ ПАССИВ | 138.92 | 100.0% |

Дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн 41.8% буюу 18.5 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагуудаас, 58.2% буюу 25.8 тэрбум төгрөгийг гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас авсан өр төлбөр эзэлж байна.

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын 27 нь /"Хөх нутаг финанс ББСБ" ХХК үйл ажиллагаа явуулаагүй/ 7.5 тэрбум төгрөгийн орлоготой, 5.8 тэрбум төгрөгийн зарлагатай, 1.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

6.3 Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-ууд

- **Ерөнхий статистик**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа ББСБ нь нийт ББСБ-уудын 8.9%, гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудын 32.4% буюу 48 ББСБ, 6 салбар, 136 ажилтан, 22,723 харилцагчдад хүрч үйл ажиллагаа эрхэлж байна.

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 148 ББСБ байгаагаас дагнан эрхэлж байгаа 48 ББСБ-уудын 45 нь Улаанбаатар хотод, 3 ББСБ орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 оны I улиралд гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудаас 3 ББСБ үйл ажиллагаагаа өргөжүүлж нэмэлт тусгай зөвшөөрөл авсан бол 1 ББСБ шинээр хөдөө орон нутагт, 1 ББСБ 2 үйл ажиллагаагаа хүчингүй болгож дан гадаад валютын арилжаа эрхлэх болсон.

- **Актив**

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын нийт активын хэмжээ 11.4 тэрбум төгрөг байгаа нь салбарын активын 1.1% байна.

Хүснэгт 26 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын актив

| Тайлангийн үзүүлэлтүүд | Дүн | Хувь |
|------------------------|---------------|-------|
| Эргэлтийн хөрөнгө | 11,140,475.42 | 49.0% |

| | | |
|---|----------------------|----------------|
| Мөнгөн хөрөнгө | 11,035,370.40 | 48.3% |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр) | 1,000.00 | 0.01% |
| Бусад хөрөнгө | 104,105.01 | 0.46% |
| Эргэлтийн бус хөрөнгө | 224,727.90 | 0.99% |
| Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр) | 224,727.90 | 0.99% |
| НИЙТ ХӨРӨНГӨ | 22,730,406.63 | 100.00% |

- **Пассив**

Нийт хөрөнгийн 93.9% буюу 10.7 тэрбум төгрөг нь хувьцаат капитал, 4.9% буюу 536.2 сая төгрөг нь хуримтлагдсан ашиг, 0.9% буюу 110.4 сая төгрөг нь өр төлбөр, 0.2% буюу 20.7 сая төгрөг нь бусад өмч байна.

Хүснэгт 27 ГВА дагнан эрхэлдэг ББСБ-уудын пассив

| Тайлангийн үзүүлэлтүүд | Дүн | Хувь |
|------------------------|----------------------|-------------|
| Өр төлбөр | 110,396.54 | 0.97% |
| Хувьцаат капитал | 10,670,862.40 | 93.89% |
| Бусад өмч | 20,747.70 | 0.18% |
| Хуримтлагдсан ашиг | 563,196.69 | 4.96% |
| Нийт пассив | 11,365,203.33 | 100% |

- **Орлого үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаанд 379.8 сая төгрөгийн орлоготой, 357.3 сая төгрөгийн зарлагатай, 22.6 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

31 ББСБ 64.7 сая төгрөгийн орлоготой, 14 ББСБ 42.2 сая төгрөгийн алдагдалтай, 3 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй байна.


Орлогын бүтцийн 92.1% буюу 376.6 сая төгрөг нь гадаад валютын арилжааны орлого, 7.0% буюу 26.5 сая төгрөг нь гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлогоос бүрдэж байгаа бол зарлагын бүтцийн хувьд 58.8% нь боловсон хүчний холбогдолтой зардал, 28.0% нь бусад зардал, 10.2% нь арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал байна.

- **Гадаад валютын арилжааны дүн мэдээ**

Хорооны гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 148 ББСБ-уудын

2018 оны 1 сараас 2018 оны 3 сар хүртэлх арилжааны дүн мэдээгээр 202.5 тэрбум төгрөгийн гадаад валют худалдан авч 205.3 тэрбум төгрөгийн гадаад валют зарсан байна.

Зураг 31 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн /2017-2018 оны 1-3 сар/



2018 оны 1 сард 47 ББСБ, 2 сард 75 ББСБ, 3 сард 88 ББСБ валют арилжааны дүн мэдээ ирүүлсэн байна.

Хүснэгт 28 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын арилжааны дүн мэдээ /2018-I улирал/

| ББСБ-ын валют арилжааны дүн | Худалдаж авсан | Зарсан |
|-----------------------------|--------------------|--------------------|
| | 202,485,970,566.31 | 205,302,240,441.31 |
| БНХАУ-ын юань | 97,791,717,198.67 | 99,415,791,791.91 |
| АНУ-ын доллар | 67,124,601,156.17 | 68,978,238,679.25 |
| Евро | 18,529,197,479.58 | 18,399,942,329.21 |
| БНСУ-ын вон | 7,366,537,236.61 | 7,463,967,527.33 |
| Японы иен | 5,385,964,572.63 | 4,961,822,120.07 |
| ОХУ-ын рубль | 3,737,177,161.89 | 3,815,022,178.76 |
| Английн фунт | 899,268,626.25 | 913,553,280.17 |
| Швейцарь франк | 623,379,285.32 | 387,684,865.41 |
| Хонконг доллар | 376,079,124.19 | 291,229,967.75 |
| Австралийн доллар | 325,114,759.67 | 326,514,444.74 |
| Сингапурын доллар | 206,305,085.25 | 195,858,626.72 |
| Канадын доллар | 73,314,625.00 | 69,029,450.00 |
| Шведийн крон | 42,930,629.08 | 42,574,950.00 |
| БНАСАУ-ын вон | 4,380,000.00 | 41,010,230.00 |
| Малайзын рингит | 3,626.00 | 0.00 |

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс: 2018 оны I улиралд 379 ББСБ 739.3 сая төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.
- Зээлийн мэдээллийн сан: Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 486 ББСБ-ын 88.2% буюу 429 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.
- Жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх: 2018 оны I улиралд Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 537 ББСБ-ын 65.7 хувь буюу 353 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 325 ББСБ хэрэгжүүлсэн байх тул Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.4 дэх хэсгийн “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

2018 оны I улиралд Хорооны ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа 537 ББСБ-ын 96.1% буюу 516 ББСБ санхүүгийн тайлан мэдээгээ бүрэн ирүүлсэн бол 5 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр, 16 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр 2018 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдлаа.

2018 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 5711 хувь нийлүүлэгчдийн 537 ББСБ 177 салбар нэгж, 4 төлөөлөгчийн газар, 2511 ажилтантайгаар Монгол улсын 21 аймагт 1,358,693 харилцагчдад хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 461 ББСБ, 124 салбар Улаанбаатар хотод, 76 ББСБ, 53 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2018 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө анх удаа 1046.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.1 хувиар буюу 248.5 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 8 хувиар буюу 77.6 тэрбум төгрөгөөр өсөж банкны салбарын нийт активын 3.6 хувьтай тэнцэж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 1-4.9 тэрбум хүртэл хөрөнгөтэй 320 ББСБ нийт активын 52.5 хувийг, 5 тэрбумаас дээш хөрөнгөтэй 32 ББСБ нийт активын 39.7 хувийг, 1 тэрбумаас доош хөрөнгөтэй 185 ББСБ нийт активын 7.8 хувийг эзэлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 706.7 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 5.0 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 590.5 тэрбум төгрөг буюу 83.5 хувийг хэвийн зээл, 37.9 тэрбум төгрөг буюу 5.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 78.3 тэрбум төгрөг буюу 11.1 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба чанаргүй зээлийн 75.2 хувьд эрсдэлийн сан байгуулсан байна. Чанаргүй зээлийн хэмжээ оны эхнээс 3.4 хувиар буюу 2.74 тэрбум төгрөгөөр буурсан бол хэвийн зээл 12.0% буюу 63.45 тэрбум төгрөгөөр, хугацаа хэтэрсэн зээл 26.8% буюу 8.03 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 486 ББСБ-аас 398 ББСБ 290.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд зээлийн жигнэсэн дундаж хүү 3.4%-тай

гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 пунктээр буусан үзүүлэлт юм. Банкны салбартай харьцуулахад жигнэсэн дундаж хүү 1.8 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын өөрийн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хэмжээ 2017 оны I улиралд 63.9 хувийг бүрдүүлж байсан бол 2018 оны I улиралд 61.7 хувийг бүрдүүлж байна. 2016-2017 оны I улирлын хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт нь 49.1%-тай байсан бол 2017-2018 оны I улиралд 26.9 хувийн өсөлт үзүүлсэн байна. 2018 оны I улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 58 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 35.3 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.4-2.4 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 284 ББСБ 52.1 хувийг эзэлж байгаа бол 0.9 тэрбумаас доош хөрөнгөтэй 195 ББСБ 12.7 хувийг бүрдүүлж байна.

Нийт ББСБ-ын 86.0% буюу 462 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 75 ББСБ буюу 14.0% нь зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР